

ГОЛ НЭРИЙН БАРААНЫ ҮНИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН МЭДЭЭЛЭЛ


/2015 оны 7 сарын 29-ны өдрийн байдлаар/

МАХНЫ ҮНЭ


2015 оны 7 сарын 29-ны өдрийн байдлаар Баруун сайхан, Хан-уул, худалдааны төвд байрлалтай мах, ногооны захын ханшаар 1 кг хонины мах дунджаар 6500 төгрөгөөр, ямааны мах 5500, адууны мах 6000, тэмээний мах 5500 төгрөгөөр тус тус худалдаалагдаж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад хонь, ямааны махны үнэ дунджаар 1516 төгрөгөөр, адууны мах 1000 төгрөгөөр тус тус буурчээ. Өмнөх 7 хоногийнхтой харьцуулахад ямааны махны үнэ дунджаар 167 төгрөгөөр өсч, харин бусад малын махны үнэ тогтвортой байна.

Зураг1.Махны үнэ 2015 оны 7 сар


Хонины махны үнэ, 1 кг, төгрөгөөр



Адууны махны үнэ, 1 кг, төгрөгөөр




Ямааны махны үнэ, 1 кг, төгрөгөөр



ГУРИЛ, БУДАА, СҮҮ, ЭЛСЭН ЧИХРИЙН ҮНЭ

2015 оны 7 сарын 29-ны өдрийн байдлаар малын шингэн сүү 2000 төгрөг, цагаан будааны үнэ дунджаар 2300 төгрөг, элсэн чихрийн үнэ дунджаар 1933 төгрөг, алтан тариа 1-р гурил 1100 төгрөгөөр худалдаалагдаж байгааг өмнөх оны мөн үетэй харьцуулахад цагаан будааны үнэ 4.5 хувиар өсч, харин алтан тариан гурил 5.7 хувиар, элсэн чихрийн үнэ 3.4 хувиар тус тус буурсан байна. Харин өмнөх 7 хоногийнхтой харьцуулахад сүүний үнэ 250 төгрөгөөр буурсан бөгөөд бусад хүнсний барааны үнэ тогтвортой байна.


Зураг 2. Цагаан будаа, элсэн чихэр, гурилын үнэ, 2015 оны 7 сар, төгрөгөөр



АВТОБЕНЗИН, ДИЗЕЛИЙН ТҮЛШНИЙ ҮНЭ

2015 оны 7 сарын 29-ны өдрийн байдлаар Даланзадгад суманд үйл ажиллагаа явуулж байгаа Шатахуун түгээх газруудын мэдээгээр бензин А-80 дунджаар 1650 төгрөг, бензин АИ-92 дунджаар 1890 төгрөг, дизелийн түлш дунджаар 1910 төгрөгийн үнэтэй худалдаалагдаж байгаа нь өмнөх долоо хоногийнхтой харьцуулахад тогтвортой байна.


Зураг 3. Авто бензин, дизелийн түлшний үнэ, 2015 он 7 сар, төгрөгөөр



ЯМААНЫ НООЛУУРЫН ҮНЭ

2015 оны 7 сарын 29-ны өдрийн байдлаар Даланзадгад суманд үйл ажиллагаа явуулж буй түүхий эдийн захад ямааны цагаан, бор ноолуур дунджаар 54000 төгрөгийн үнэтэй худалдаалагдаж байгаа нь өмнөх долоо хоногийнхтой харьцуулахад цагаан ноолуур 1000 төгрөгөөр буурчээ.

Зураг 4. Ямааны ноолуурын үнэ, 2015 он 7 сар, төгрөгөөр



Өмнөговь аймгийн Статистикийн хэлтэс.